

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-10-07

Өндөртолгой

Үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2025 оны 10 дугаар сарын 14-ний “Мягмар” гарагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх.

8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;

8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;

8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;

8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах;

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Авто замын хөдөлгөөнд оролцож буй дугааргүй тээврийн хэрэгсэл болон элс, хайрга ачсан, барилгын талбайгаас гарч буй том оврын тээврийн хэрэгслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаж, замын хөдөлгөөний дүрмийг мөрдүүлэх.	Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсэг
2	Эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй үзүүлж, үйлчилгээний чанарт хяналт тавьж, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлж, маск зүүлгэх аян өрнүүлэх.	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн төв
3	Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын сахилга, хариуцлагыг сайжруулах, хэрэгжилтэд хяналт тавих.	Засаг даргын орлогч Х.Цогцэцэг, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн төв
4	Хүүхдийн гар утасны хэрэглээг бууруулах, донтолтоос урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, танилцуулах.	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс
5	Ерөнхий боловсролын сургуулиудад үе тэнгийнхний дээрэлхэлтийг зогсоох, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ авч ажиллах.	Боловсролын хэлтэс, Цагдаагийн хэлтэс
6	Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрийнхээ явган хүний замыг тэгшлэх, засварлах, газар дээр явж ажиллах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс,

		Багахангай тохижилт ОНӨААТҮГ
7	2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор мал гаргах ажлыг шуурхай зохион байгуулах тухай захирамж гаргах.	Цагдаагийн хэлтэс, Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасаг
8	Нохой, муур барих ажлыг зохион байгуулах тухай захирамж гаргах.	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс, Хороод, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
9	Дүүргүүд өөсрдийнхөө нутаг дэвсгэрт ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах төлөвлөлт хийх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
10	2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Олон улсын хүүхдийн “Найрамдал-2” зуслан байгуулах төслийг хэрэгжүүлэх талаар Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулах тул бэлтгэлийг хангах.	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Ажлын хэсэг
11	Хойд жигүүрийн шугам солих ажлын нөхөн сэргээлт, цэвэрлэгээ үйлчилгээг зохион байгуулах.	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс, Илч-Орд ОНӨААТҮГ
12	Хот нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын машин механизм, тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах.	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Илч-Орд ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, Ус суваг ашиглалтын товчоо
13	Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд машин механизм, шугам сүлжээний сэлбэг хэрэгслүүдийн татан авалт хийх, нийт байгууллагууд шаардлагатай багаж, хэрэгслийн бэлтгэлийг сайтар хангах.	
14	Хот нийтийн аж ахуй, ногоон байгууламж, тохижилтын чиглэлээр мэдээлэл бэлтгэн нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд танилцуулахад бэлтгэх.	
15	2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэх архивын Улсын үзлэгийн бэлтгэлийг хангах.	Архивын хэлтэс, нийт байгууллагууд
16	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлыг сард 2 удаа зохион байгуулахаар төлөвлөсөн тул бэлтгэлийг ханган, хэлэлцэх асуудал, танилцуулах мэдээлэлд анхаарах.	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
17	Нийтийн ариун цэврийн байгууламж болон Сити сауны ашиглалтын нөхцөл, орлого, зарлагын статистик мэдээллийг нэгтгэн танилцуулах.	Илч-Орд ОНӨААТҮГ
18	“Багахангайн теле камерын хяналтын дэд төв” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар танилцуулах.	“Багахангайн теле камерын хяналтын дэд төв” ОНӨААТҮГ
19	НЕБ-ын 91 дүгээр сургуулийн 640 хүүхдийн суудалтай хичээлийн байрны тайлбар, анги танхим, бүлгийн зохион байгуулалт, зориулалтын талаар статистик мэдээлэл бэлтгэх, хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлох.	НЕБ-ын 91 дүгээр сургууль
20	Дүүргийн Засаг даргаас өгсөн чиглэлийн дагуу НЕБ-ын 94 дүгээр сургуулийн удирдах албан тушаалтнууд 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр төлөвлөгөөний биелэлтийг танилцуулах.	НЕБ-ын 94 дүгээр сургууль
21	Дүүргийн 1 дүгээр хорооны Хөлбөмбөгийн талбайг	Багахангай тохижилт

	тойрсон гүйлтийн замыг засварлах хүрээнд резинэн будгаар будах төсөв тооцооллыг гарган танилцуулах.	ОНӨААТҮГ
22	ЗДТГ-ын зүүн зогсоолоос 4 дүгээр байрны уулзвар хүртэлх (Автобусны зогсоол байгуулах хүрээнд) талбайн техникийн зургийг гүйцэтгэж танилцуулах.	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс
23	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01, 03, 04 дүгээр албан даалгавруудын хүрээнд холбогдох тоон мэдээллүүдийг нэгтгэн 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн дотор ирүүлэх.	Нийт байгууллагууд

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ОДБАЯР